



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 41


Улаанбаатар хот

Төслийн удирдах хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2017 оны 7 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан "Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл"-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийн Хуваарь 2-ын 1 дүгээр хэсгийн А.1(а) заалт, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ний өдрийн 196 дугаар тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 10.1.6 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг."Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл"-ийг бодлого, үйл ажиллагааны удирдамжаар хангах, төслийн хэрэгжилтийг хянах, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах, ерөнхий хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Төслийн удирдах хороог байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр.Төслийн хэрэгжилтийг хянаж, бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоог хангаж ажиллахыг Төслийн удирдах хороо /С.Наранцогт/-нд үүрэг болгосугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

Сангийн сайдын 2018 оны 02 дугаар сарын  
28-ны өдрийн 41 дугаар тушаалын  
хавсралт



**Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүн**

- Удирдах хорооны дарга: Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.
- Гишүүд:
- Санхүүгийн зохицуулах хорооны дарга;
  - Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч;
  - Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
  - Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга;
  - Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга;
  - Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга;
  - Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга;
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга.
- Нарийн бичгийн дарга: “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх” төслийн зохицуулагч.